



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/400

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Оросын Холбооны Улсын Тува Улсын Кызыл хотноо зохион байгуулах “Сибирийн хэлэлцээр” хэмээх Оросын Холбооны Улсуудын субъектуудын эдийн засгийн хамтын ажиллагааны Бүс нутгийн Холбооны ээлжит хуралдаанд оролцож, автозамын коридор байгуулах тухай протоколд гарын үсэг зурах ажлаар ажиллах аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардалд зарцуулах төсвийг хавсралтаар баталж зарцуулсугай..

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2.200.000 төгрөг /Хоёр сая хоёр зуун мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



02 01095
D/Zax-A/400-Da

Аймгийн Засаг даргын 2019 оны
06 дугаар сарын 25-ны өдрийн А/400 дүгээр
захирамжийн хавсралт



ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ТУВА УЛСЫН КЫЗЫЛ ХОТНОО БОЛОХ
“СИБИРИЙН ХЭЛЭЛЦЭЭР” АВТО ЗАМЫН КОРИДОР БАЙГУУЛАХ ПОРТОКОЛД
ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

2019.06.24

Ховд

Д.д	Явах маршрут	ХНэгжТоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1	Ховд- Улаангом- Кызыл (740км*2 талдаа*20/100*2510)	296л	2510	742.960
2	Жолоочийн хариуцлагын даатгал /хөдөлгүүрийн багтаамж/	1 ш	1	120.000
3	Буудал /2 хонох /	3 өрөө	4000*42.80	1.028.000
4	Бэлэг дурсгал	3	103.013	309.040
Нийт:				2.200.000

-oOo-